АШУҮИС-ийн Сувилахуйн сургуулийн оюутнуудын сэтгэл хөдлөлийн оюун ухааны түвшинг үнэлсэн дүн

Г.Булган[1], Э.Наранцэцэг[1], Ш.Ичинхорлоо[1], Г.Ганхуяг[1], Б.Оюунгоо[1]

[1]АШУҮИС, Сувилахуйн сургууль
Цахим шуудан: bulgan.guntev@mnums.edu.mn, Утас: 77889688

Түлхүүр үг:

Сувилахуйн оюутнууд
Сэтгэл хөдлөлийн харьцуулалт

Товч утга:

Үндэслэл: EQ (Emotional quotient) буюу сэтгэл хөдлөлийн оюун ухаан гэдэг нь өөрийн болон бусад хүмүүсийг юу хөдөлгөж, идэвхтэй байлгадаг болон тэдэнтэй хэрхэн хамтарч ажиллахыг ойлгож, мэдрэх зэрэг цогц чадвар юм. Манай улсад энэ чиглэлээр судалгаа хийдэг байгууллагууд байдаг ч боловсролын салбарт төдийлөн судлагдаагүй байна. Судлаач Г.Ичинхорлоо нарын хийсэн судалгаанд 142 өсвөр насны хүүхэд хамрагдсанаас 64.1% нь сэтгэл хөдлөлийн оюун ухааны түвшин доогуур үзүүлэлттэй гэж тодорхойлогдсон бөгөөд энэ нь өөрийн ухамсар, өөрийн сэтгэл хөдлөлийг удирдах, өөрийн сэдэлжүүлэлт, бусдын мэдрэмж сэтгэл хөдлөлийг хуваалцах, бусдын сэтгэл хөдлөлийг хөгжүүлэх хэрэгцээ шаардлага байгааг харуулж байна. **Зорилго:** АШУҮИС-ийн Сувилахуйн сургуулийн сувилахуйн ангийн оюутнуудын сэтгэл хөдлөлийн оюун ухааны түвшинг тодорхойлох. **Арга, аргачлал:** Судалгааны мэдээ мэдээллийг тоон судалгааны аргаар нэг агшингийн загвараар хийж гүйцэтгэв. Судалгаанд АШУҮИС-ийн Сувилахуйн сургуулийн сувилахуйн ангид суралцдаг 110 оюутныг хамруулж хүн ам зүйн мэдээлэл цуглуулах асуумж, судлаач Н. Холл нарын сэтгэл хөдлөлийн оюун ухааны түвшинг тодорхойлох асуумжийг зөвшөөрөл авч хэрэглэн судалгааны мэдээллийг цуглуулсан. **Үр дүн:** Судалгаанд АШУҮИС-ийн Сувилахуйн сургуулийн сувилахуйн ангийн 110 оюутныг (дундаж нас 21.64±5.125) хамруулсан. Судалгаанд оролцогчдын 99.1%(109)-ийг эмэгтэйчүүд эзэлж байв. Судалгаанд оролцогчдын сэтгэл хөдлөлийн 5 түвшинг хэсэгчлэн тооцоолоход сэтгэл хөдлөлөө танин мэдэх чадвар 36.4% бага, 45.5% дунд, 18.2% нь өндөр гэж тодорхойлогдов. Харин сэтгэл хөдлөлөө удирдах чадвар 65.5% бага, 31.8% дунд, 2.7% өндөр байв. Өөрийгөө хөгжүүлэх чадвар 26.4 бага, 46.4% дунд, 27.3% өндөр байгаа нь тодорхойлогдсон. Бусдыг ойлгох чадвар 27.3% бага, 56.4% дунд, 16.4% өндөр байна. Бусадтай харилцах чадвар 28.3% бага, 50.9% дунд, 20.9% өндөр байв. Сэтгэл хөдлөлийн оюун ухааны ерөнхий түвшинг авч үзэхэд 34.5% бага, 60% дунд, 5.5% өндөр үзүүлэлттэй байна. Эдгээр үр дүнгээс харахад оюутнуудын сэтгэл хөтлөлөө удирдах чадвар хамгийн бага, өөрийгөө идэвхжүүлэх чадвар хамгийн өндөр байна. **Дүгнэлт:** Судалгаанд оролцсон оюутнуудын сэтгэл хөдлөлөө удирдах чадвар сул, бусадтай харилцах өөрийгөө хөгжүүлэх чадвар сайн байна. Цаашид оюутнуудын сэтгэл хөдлөлөө удирдах чадварыг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Үндэслэл: EQ (Emotional quotient) буюу сэтгэл хөдлөлийн оюун ухаан гэдэг нь өөрийн болон бусад хүмүүсийг юу хөдөлгөж, идэвхтэй байлгадаг болон тэдэнтэй хэрхэн хамтарч ажиллахыг ойлгож, мэдрэх зэрэг цогц чадвар юм.[1,2] Сэтгэл хөдлөлийн оюун ухаан нь бидний хэрхэн бодож, мэдэрч, хэрхэн ажиллаж

байгааг таньж мэдэх, ойлгох, сонгох арга юм. Энэ нь хүмүүстэй харилцах харилцаа, өөрсдийн ойлголтыг бий болгодог ба бид хэрхэн, яагаад сурч байгаа, тэргүүлэх чиглэлийг тодорхойлох боломжийг олгодог.[3] Хүн сэтгэл хөдлөлийн боловсролыг эзэмшихгүйгээр сорилтод асуудлууд болон боломжуудын утгуудыг ойлгохгүйгээр хөгжих дэвших боломжгүй гэж судлаачид дурьдсан байна.[4] Энэхүү шинжлэх ухааны талаар АНУ болон Европын улс орнуудад ихээхэн судалгаанууд хийгдэж боловсрол, бизнес, үйлдвэрлэл гээд хүн ажиллаж буй томоохон салбаруудад судалгаа шинжилгээний үр дүнд хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрүүд нь үр дүнгээ үзэж эрчимтэй хөгжиж байгааг онцгойлон тэмдэглэсэн байна.[5]

Сэтгэл хөдлөлийн оюун ухаан нь академик амжилт буюу сурлагын болон гүйцэтгэлийн амжилтыг сайжруулахад чиглэхээс гадна амьдрал ахуйдаа, ажил мэргэжилдээ гаргах амжилтын үндэс болдог гэж судлаачид үзэж байна.[6,7] Харвардын эрдэмтдийн судалгаагаанд хүний амжилтын ердөө 20-25 хувь нь IQ-аас, үлдсэн 75-80 хувь нь EQ буюу сэтгэл хөдлөлөө удирдах чадвараас шалтгаалдаг гэсэн дүн гарсан байна.[8] Д. Гоулмэн “Сэтгэл хөдлөлийн оюун ухаан” номондоо сэтгэл хөдлөлийн оюун ухааныг СӨБ, ЕБС, Их дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт багц байдлаар хэрэгжүүлсэний үр дүнд оюутнуудын 40% нь сурлагын амжилт сайжирсан, 50%-д нь ерөнхий амжилт нь ахисан дүн мэдээг дурьдсан байна.[9]

Манай улсад энэ чиглэлээр судалгаа хийдэг судалгааны байгууллагууд байдаг ч боловсролын салбарт төдийлөн судлагдаагүй байна. Судлаач Г.Ичинхорлоо нарын судалсанаар 142 өсвөр насны хүүхдүүдээс 64.1% нь сэтгэлхөдлөлийн оюун ухааны түвшин доогуур үзүүлэлттэй гарсан бөгөөд энэ нь өөрийн ухамсар, өөрийн сэтгэл хөдлөлийг удирдах, өөрийн сэдэлжүүлэлт, бусдын мэдрэмж сэтгэл хөдлөлийг хуваалцах, бусдын сэтгэл хөдлөлийг хөгжүүлэх хэрэгцээ шаардлага байгааг харуулж байна.[10] Мөн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж буй мэргэжилтний сэтгэн бодох, шийдвэр гаргах чавдар 50%, хандлага 50%-ийг тус тус эзэлдэг бөгөөд үйлчлүүлэгчдийн сэтгэл хангалуун бус байгаа шалтгаанд нь мэргэжилтний мэдлэг дутмаг 20%, харилцааны доголдол 15%, сэтгэн бодох шийдвэр гаргах чадвар дутмаг 15%, сөрөг хандлага 50% зэрэг шалтгаантай гэж судалгаанд тодорхойлжээ.[11]

Оросын судлаач Butler C (2006) нарын судалгаагаар ажил мэргэжлийн онцлогоос хамаарч хувь хүний аль нэг сэтгэл хөдлөлийн чадвар нь илүү хөгжиж байдаг.[12] Бусдыг ойлгох, бусадтай харилцах ур чадвар нь сувилагч бүрийн хувьд маш чухал бөгөөд тэд оношийг зөв тайлбарлаж, өвчтөнд тэдний нөхцөл байдалд санал болгож буй процедур, эмчилгээг ойлгох боломжийг олгодог. Түүнчлэн, үйлчлүүлэгчийн эрүүл мэндийн түүхийн талаар үнэн зөв мэдээлэл олж авахын тулд өвчтөн болон түүний гэр бүлийнхэнтэй харилцан хүндэтгэл, итгэлцэлд суурилсан бат бөх түншлэлийг бий болгох ёстой. Тиймээс эмч, сувилагч нар өвчтөндөө өрөвдөх сэтгэл, энэрэнгүй ханддаг байх ёстой гэжээ.[13]

Иймд EQ чадвар нь оюутнуудын эрүүл мэнд, ирээдүйн ажлын байран дахь амжилтыг сайжруулахад зайлшгүй шаардлагатай ур чадвар гэдгийг сурган хүмүүжүүлэгчид, хууль тогтоогчид санал нэгтэй хүлээн зөвшөөрч байгаа[14,15] нь бидний сувилахуйн хөтөлбөрөөр суралцаж буй оюутнуудын сэтгэл хөдлөлийн оюун ухааныг тодорхойлон судлах үндэслэл болж байна.

Зорилго: АШУҮИС-ийн Сувилахуйн сургуулийн сувилахуйн ангийн оюутнуудын сэтгэл хөдлөлийн оюун ухааны түвшинг тодорхойлох.

Арга, аргачлал: Судалгааны мэдээ мэдээллийг тоон судалгааны аргаар, нэг агшингийн загвараар хийж гүйцэтгэв. Судалгаанд АШУҮИС-ийн Сувилахуйн сургуулийн сувилахуйн ангид суралцдаг 110 оюутныг хамруулж хүн ам зүйн мэдээлэл цуглуулах асуумж, (Н.Холл) сэтгэл хөдлөлийн оюун ухааны түвшинг тодорхойлох асуумжийг зөвшөөрөл авч хэрэглэн судалгааны мэдээллийг цуглуулсан. 5 бүлэг 30 асуумжаас сэтгэл хөдлөлөө танин мэдэх чадвар, сэтгэл хөдлөлөө удирдах чадварын асуумжийг хэрэглэж оноо тодорхойлох үнэлгээний үзүүлэлтийг огт санал нийлэхгүй бол -3 оноо, үндсэндээ санал нийлэхгүй бол -2 оноо, бага зэрэг санал нийлэхгүй бол -1 оноо, Бага зэрэг санал байна бол +1 оноо, Үндсэндээ санал нийлж байна бол +2 оноо, Бүрэн зөвшөөрч байна бол +3 оноо хэмээн оноолох бөгөөд сэтгэл хөдлөлийн оюун ухааны түвшинг тодорхойлох асуумж бөглөхдөө асуумж тус бүрт нэг хариулт сонгуулж, нийт оноог нэгтгэн тооцоолсон. Сэтгэл хөдлөлийн оюун ухааны түвшинг тодорхойлох үнэлгээ (Н. Холл) 7≥ бол бага, 8-13 бол дунд, 14≤ бол өндөр гэж үнэлсэн. Судалгааны мэдээллийг SPSS 22 программаар боловсруулалтыг хийж гүйцэтгэв. АШУҮИС-ийн Судалгааны ёс зүй хяналтын хорооны 2022 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн хурлаар (№2022/3-03) хэлэлцүүлэн судалгааны ажлыг хийх ёс зүйн зөвшөөрөл авсан.

Үр дүн: Судалгаанд АШУҮИС-ийн Сувилахуйн сургуулийн сувилахуйн ангийн 110 оюутныг (дундаж нас 21.64±5.125 жил) хамруулсан. Судалгаанд оролцогчдын 99.1% (109)-ийг эмэгтэйчүүд эзэлж байна. Суралцаж буй боловсролын зэргээр нь авч үзэхэд сувилахуйн бакавларын ангид сурч байгаа оюутан 18.2% (20)-ийг эзэлж байна. Суралцаж буй дамжаагаар нь авч үзэхэд II дамжааныхан 84.5% (81.8)-ийг, III дамжааныхан 3.6% (13)-ийг, IV дамжааныхан 11.8% (13)-ийг эзэлж байна. Улаанбаатар хотын харьяалалтай оюутантай 43.6%(48), Хөдөө орон нутгийн харьяалалтай оюутан 56.4%(62)-ийг эзэлж байв.

Судалгаанд оролцогчдын сэтгэл хөдлөлийн 5 түвшинг хэсэгчлэн тооцоолоход сэтгэл хөдлөлөө танин мэдэх чадвар 36.4% бага, 45.5% дунд, 18.2% нь өндөр байна. Сэтгэл хөдлөлөө удирдах чадвар 65.5% бага, 31.8% дунд, 2.7% өндөр байна. Өөрийгөө хөгжүүлэх чадвар 26.4 бага, 46.4% дунд, 27.3% өндөр байна. Бусдыг ойлгох чадвар 27.3% бага, 56.4% дунд, 16.4% өндөр байна. Бусадтай харилцах чадвар 28.3% бага, 50.9% дунд, 20.9% өндөр байна. Сэтгэл хөдлөлийн

оюун ухааны нийлбэр түвшинг авч үзэхэд 34.5% бага, 60% дунд, 5.5% өндөр үзүүлэлттэй байна. Эдгээр үр дүнгээс харахад оюутнуудын сэтгэл хөтлөлөө удирдах чадвар хамгийн бага, өөрийгөө идэвхжүүлэх чадвар хамгийн өндөр байгаа нь тус тус тодорхойлогдов. (Хүснэгт 1)

Хүснэгт 1. Сувилахуйн ангийн оюутнуудын сэтгэл хөдлөлийн оюун ухааны түвшин (хувиар, %)

	Үзүүлэлт	Тоо	Хувь
Сэтгэл хөдлөлийн оюун ухааны хэсэгчилсэн түвшин	Сэтгэл хөдлөлөө танин мэдэх чадвар		
	Бага	40	36.4
	Дунд	50	45.5
	Өндөр	20	18.2
	Сэтгэл хөдлөлөө удирдах чадвар		
	Бага	72	**65.5**
	Дунд	35	31.8
	Өндөр	3	2.7
	Өөрийгөө идэвхжүүлэх чадвар		
	Бага	29	26.4
	Дунд	51	46.4
	Өндөр	30	27.3
	Бусдыг ойлгох чадвар		
	Бага	30	27.3
	Дунд	62	56.4
	Өндөр	18	16.4
	Бусадтай харилцах чадвар		
	Бага	31	28.3
	Дунд	56	50.9
	Өндөр	23	20.9
Сэтгэл хөдлөлийн оюун ухааны нийлбэр түвшин			
	Бага	38	34.5
	Дунд	66	60.0
	Өндөр	6	5.5
Нийт		**110**	**100.0**

Судалгаанд оролцогчдын сэтгэл хөдлөлийн хэсэгчилсэн 5 түвшин болон нийлбэрийг тооцоолов. Сэтгэл хөдлөлөө танин мэдэх чадварын дундаж 8.34±5.85, сэтгэл хөдлөлөө удирдах чадварын дундаж 4.87±5.78, өөрийгөө идэвхжүүлэх чадвар 9.90±6.82, бусдыг ойлгох чадварын дундаж 8.53±6.22, бусадтай харилцах чадварын дундаж 9.14±6.26 байна. Сэтгэл хөдлөлийн оюун ухааны нийлбэр түвшний дундаж 40.20±26.55 байна. Эдгээр үр дүнгээс харахад оюутнуудын бусадтай харилцах, өөрийгөө хөгжүүлэх чадвар сайн, сэтгэл хөдлөлөө удидах чадвар сул байв. (Хүснэгт 2)

Хүснэгт 2. Сувилахуйн ангийн оюутнуудын сэтгэл хөдлөлийн оюун ухааны үзүүлэлтүүдийг тодорхойлсон дүн

Үзүүлэлт		Нийт	Хамгийн их	Хамгийн бага	Дундаж утга	Стандарт хазайлт
Сэтгэл хөдлөлийн оюун ухааны хэсэгчилсэн түвшин	Сэтгэл хөдлөлөө танин мэдэх чадвар	110	17	-16	8.3455	5.8473
	Сэтгэл хөдлөлөө удирдах чадвар	110	16	-18	4.8727	5.7789
	Өөрийгөө идэвхжүүлэх чадвар	110	18	-18	9.3000	6.8221
	Бусдыг ойлгох чадвар	110	18	-18	8.5364	6.2231
	Бусадтай харилцах чадвар	110	18	-18	9.1455	6.2557
Сэтгэл хөдлөлийн оюун ухааны нийлбэр түвшин		110	79	-88	40.2000	26.5574

Хэлцэмж: Бид АШУҮИС-ийн Сувилахуйн сургуулийн 110 оюутны сэтгэл хөдлөлийн оюун ухааны түвшинг судлахад 34.5% нь бага, 60% нь дунд, 5.5% нь өндөр байв.

Судлаач Almansour A (2023) нар сувилахуйн ангийн төгсөх дамжааны 322 оюутны оюун ухааны сэтгэл хөдлөлийг судлахад 96.6% нь сэтгэл хөдлөлийн оюуны түвшин өндөр байна гэж тодорхойлжээ.[22]

Бидний судалгаанд хамрагдсан оюутнуудын 71.8% нь сэтгэл хөдлөлийн түвшин дунд болон өндөр байгаа нь судлаач Ахамед нарын судалгаатай харьцуулахад бага байна. Энэ нь бидний судалгаанд II, III дамжааны оюутан хамрагдсан Ахамед нарын судалгаанд төгсөх дамжааны оюутнууд хамрагдсантай холбоотой гэж үзэж байна.

Судлаач Cerit E (2014) нар сувилахуйн ангид сурдаг 183 оюутны сэтгэл хөдлөлийн оюун ухааны түвшинг тодорхойлоход 30.1% нь бага, 52.2% хувь дунд, 17.4% нь өндөр байна гэж дүгнэжээ.[23] Бидний судалгаанд хамрагдсан сувилахуйн ангийн оюутнуудын сэтгэл хөдлөлийн түвшин 34.5% бага, 60% дунд, 5.5% өндөр байгаа нь судлаач Cerit E (2014) нарын үр дүнтэй дүйж байна.

Судлаач Elmira K (2021) нар сэтгэл хөдлөлийн оюун ухаан нь сувилахуйн тусламж үйлчилгээний чанар, үнэлгээнд эерэгээр нөлөөлдөг учраас сувилахуйн бодлого боловсруулагчид сувилагчийн сэтгэл хөдлөлийн оюун ухааны чадавхийг бэхжүүлэх, сувилахуйн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах боловсролыг хөтөлбөрүүдийг авч үзэхийг зөвлөж байгаа нь бидний судалгааны зорилготой дүйж байна[21].

Судлаач Г.Дабааням (2023) нар судалгаандаа сувилахуйн оюутнуудын сэтгэл хөдлөлийн түвшин 66.7% нь сайн, 32.4% нь дунд, 1% хувь нь муу байсан бөгөөд сувилахуйн оюутнуудын EQ буюу сэтгэл хөдлөлийн оюун ухааны түвшин харьцангуй сайн байгаа нь бидний судалгааны үр дүнгээс ялгаатай байгаа нь судалгаанд хамрагдсан оюутнуудын дамжаа өөр байсантай холбоотой гэж үзэж байна[24].

Дүгнэлт: Судалгаанд оролцсон оюутнуудын сэтгэл хөдлөлөө удирдах чадвар сул, бусадтай харилцах өөрийгөө хөгжүүлэх чадвар сайн байна. Цаашид оюутнуудын сэтгэл хөдлөлөө удирдах чадварыг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Ном зүй:

1. *Cherniss C. Emotional intelligence: What it is and why it matters. Rutgers University, Graduate School of Applied and Professional Psychology; 2000.*
2. *Отгонбаяр Р. Сэтгэл хөдлөл, харилцааны чадварын EQ хичээлийн сурах бичиг. УБ. 2004.*
3. *Birks Y, McKendree J, Watt I. Emotional intelligence and perceived stress in healthcare students: a multi-institutional, multi-professional survey. BMC Med Educ. 2009;9:61.*
4. *Darwin C. The expression of the emotions in man and animals. University of Chicago press; 2015.*
5. *Goleman D. Emotional development and emotional intelligence: Educational implications. Basic Books; 1997.*
6. *Estrada M, Monferrer D, Rodríguez A, Moliner MÁ. Does emotional intelligence influence academic performance? The role of compassion and engagement in education for sustainable development. Sustainability. 2021;13(4):1721.*
7. *Mo Y. Measuring and enhancing the emotional intelligence o f built environment students, Doctoral dissertation). Loughborough University Institutional Repository; 2010.*
8. *Johnson DR. Emotional intelligence as a crucial component to medical education. International journal of medical education. 2015;6:179.*
9. *Goleman D. Emotional intelligence. Bloomsbury Publishing; 2020.*
10. *Ичинхорлоо Г. Өсвөр насны хүүхдийн сэтгэл хөдлөлийн оюун ухааныг судалсан үр дүн. 2021.*
11. *Kolstø SD. Patterns in students' argumentation confronted with a risk-focused socio-scientific issue. International Journal of Science Education. 2006;28(14):1689-1716.*
12. *Butler CJ, Chinowsky PS. Emotional intelligence and leadership behavior in construction executives. Journal of management in engineering. 2006;22(3):119-125.*
13. *Mărginean CO, Melit LE, Chinceşan M, et al. Communication skills in pediatrics–the relationship between pediatrician and child. Medicine. 2017;96(43).*
14. *Abe K, Niwa M, Fujisaki K, Suzuki Y. Associations between emotional intelligence, empathy and personality in Japanese medical students. BMC medical education. 2018;18(1):1-9.*
15. *Extremera Pacheco N, Rey Peña L, Sánchez Álvarez N. Validation of the Spanish version of the Wong Law emotional intelligence scale (WLEIS-S). Psicothema. 2019.*
16. *Goleman D. Emotional Intelligence, New York, NY, England. Bantam Books, Inc; 1995.*
17. *Salovey P, Bedell BT, Detweiler JB, Mayer JD. Current directions in emotional intelligence research. 2000.*
18. *Chapin FS. Preliminary standardization of a social insight scale. American Sociological Review. 1942;7(2):214-225.*
19. *Wechsler D. The measurement of adult intelligence. The Journal of Nervous and Mental Disease. 1940;91(4):548.*
20. *Gardner H. The theory of multiple intelligences. Early Professional Development for Teachers. 2012;133.*
21. *Elmira Khademi, Mohammad Abdi, Mohammad Saeidi, Shahram Piri, and Robab Mohammadian Emotional Intelligence and Quality of Nursing Care: A Need for Continuous Professional Development, Iran J Nurs Midwifery Res. 2021 Jul-Aug; 26(4):361–367. Published online 2021 Jul 20. doi: 10.4103/ijnmr.IJNMR_268_19 PMCID: PMC8344623, PMID: 34422618*
22. *Almansour, A. M. (2023). "The level of emotional intelligence among Saudi nursing students: A cross-sectional study." Belitung Nurs J 9(5): 471-477.*
23. *Cerit, E. and N. G. Beser (2014). "Levels of emotional intelligence of nursing students." International Journal of Caring Sciences 7(3): 936-945.*
24. *Г.Дабааням нарын Хувь хүний EQ буюу сэтгэл хөдлөлөө үнэлсэн оюутны өөрийн үнэлгээний үр дүн, Оюунлаг оюутан ЭШБХ 2023, 2023*

Evaluation of emotional intelligence level of nursing students

Bulgan G[1], Narantsesteg E[1], Ichinkhorloo Sh[1], Gankhuyag G[1], Oyungoo B[1]

[1]School of Nursing, MNUMS
E-mail: bulgan.guntev@mnums.edu.mn, Tel: +976-77889688

Background: EQ (Emotional Quotient) or Emotional Intelligence is a complex ability to understand and feel what motivates you and others and how to work with them. Although there are research institutions in our country that conduct research in this field, it has not been studied much in the field of education. According to the research conducted by the researcher G. Ichinkhorloo, 64.1% of the 142 teenagers included in the sample had a low level of emotional intelligence, which means the need to develop one's own awareness, manage one's emotions, one's motivation, share the feelings and emotions of others, and develop the emotions of others. shows that there is a need.
Aim: To determine the level of emotional intelligence of nursing students of the School of Nursing of MNUMS.
Materials and Methods: Research data were collected using a quantitative research method using a single-moment model. In the study, 110 students studying nursing at the School of Nursing of ASUU were included in the demographic data collection questionnaire, researcher N. Survey data were collected using the Hall Emotional Intelligence Scale with permission.
Results: 110 2nd-3rd year nursing students (mean age 21.64±5.125) of the School of Nursing of ASUU were included in the study. 99.1% (109) of the respondents are women. Partially calculating the 5 emotional levels of the respondents, 36.4% have low, 45.5% medium, and 18.2% high. 65.5% have low emotional control ability, 31.8% medium, and 2.7% high. Self-development ability is low in 26.4%, medium in 46.4%, and high in 27.3%. The ability to understand others is low in 27.3%, medium in 56.4%, and high in 16.4%. The ability to communicate with others is low in 28.3%, medium in 50.9%, and high in 20.9%. Considering the total level of emotional intelligence, 34.5% are low, 60% are medium, and 5.5% are high. These results show that students have the lowest self-regulation skills and the highest self-motivation skills.
Conclusion: The students who participated in the study have poor emotional control skills and good self-development skills in communicating with others. In the future, it is necessary to increase the ability of students to manage their emotions.

Keywords: Nursing students, Emotional comparison